

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4.5 дугаар зүйл, "Эрчимбаян өлгий" ХК-ийн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн Э/26 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Эрчимбаян Өлгий" ХК (М.Тилеуберди)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 537 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал			Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллага	Эзлэхүүнээр халаалт		Төг/м ³	2,400.0
		Хэмжүүрээр халаалт	хувьсах	Төг/ГЖ	36,712.0
			тогтмол	Төг/м ³	1,414.0

--oOo--

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ СУМЫН
ҮЙЛДВЭР, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал			Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	Эзлэхүүнээр халаалт		Төг/м³	1,800.0
		Хэмжүүрээр халаалт	хувьсах	Төг/ГЖ	27,534.0
			тогтмол	Төг/м³	1,060.0
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “00” –ын өрөөний халаалт хамаарна)			Төг/м²	1,200.0
3	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан			Төг/хүн	2,800.0
4	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м2 хүртэлх талбайтай айл өрх		Төг/сар	3,000.0
		41 м2-аас 80 м2 хүртэлх талбайтай айл өрх		Төг/сар	5,000.0
		81 м2-ээс дээш талбайтай айл өрх		Төг/сар	10,000.0

--oOo--